

## **ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ ЭРХ ДУУСГАВАР БОЛОХ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ ЭРХ СЭРГЭЭХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхтэй болон Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцид нэгдсэн орнуудаас олгосон, уг конвенцид нийцсэн жолоодох эрхийн буюу олон улсын жолоодох эрхийн хүчин төгөлдөр үнэмлэх бүхий гадаад улсын иргэн, харъяалалгүй хүнд энэ журам хамаарна.

### **Хоёр. Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох**

2.1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болно.

2.2.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу дараахь эрх бүхий алба хаагч хасна:

2.2.1.нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын замын цагдаагийн зохицуулагч, ахлах зохицуулагч;

2.2.2.шүүгч, хэрэг бүртгэгч, мөрдөгч;

2.2.3.хэсгийн төлөөлөгч.

2.3.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасахаар заасан зөрчлийг илрүүлсэн эрх бүхий алба хаагч жолоочийн бүртгэлийн санд мэдээллийг даруй оруулна. Жолоочийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлгүй этгээдийн гаргасан зөрчлийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан мэдээллийн санд бүртгэнэ.

24.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг холбогдох хуульд заасны дагуу хассан эрх бүхий алба хаагч, хуульд заасан гомдол гаргах хугацаа өнгөрсний дараа жолоодох эрхийн үнэмлэх, эсхүл жолоочийн түр зөвшөөрлийн зүүн доод буланг хайчилж /цоолох/ хүчингүй болгон зөрчлийн хэрэгт хавсаргана.

2.5.Жолоодох эрхийн үнэмлэхийг хүчингүй болгосон тухай зөрчил гаргагчид мэдэгдэж, дээд шатны байгууллага, албан тушаалтан, шүүхэд гомдол гаргах эрхийг танилцуулна.

2.6.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-18.1.3-т заасан үндэслэлээр тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болсон тохиолдолд зөрчил шалгаж шийдвэрлэсэн алба хаагч нь жолоодох эрхийг хүчингүйд тооцож, хуульд заасан шийтгэлийг оногдуулна. Энэ тохиолдолд жолоодох эрхийг үнэмлэхийг хураахгүй.

2.7.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан тухай мэдээллийг энэхүү журмын 2.2-т заасан эрх бүхий алба хаагч ажлын 3 хоногт багтаан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасан мэдээллийн санд бүртгэнэ.

2.8.Замын хөдөлгөөний тухай Венийн конвенцид нэгдсэн орнуудаас олгосон, уг конвенцид нийцсэн жолоодох эрхийн буюу олон улсын жолоодох эрхийн хүчин төгөлдөр үнэмлэх бүхий гадаад улсын иргэн хуульд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасахаар заасан зөрчил үйлдсэн тохиолдолд үнэмлэхийг

хурааж, зөрчлийг хуульд заасны дагуу шийдвэрлэн жолоодох эрхийн үнэмлэхийг холбогдох шийдвэрийн хамт цагдаагийн төв байгууллагын Интерполын үндэсний төв товчоогоор уламжлуулан гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.9.Гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэж, шүүгчийн шийдвэрээр тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан захирамжийг үндэслэн мэдээллийг цагдаагийн төв байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгж нь жолоочийн бүртгэл мэдээллийн санд оруулна.

### **Гурав. Тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх**

3.1.Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болсон хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг дараахь тохиолдолд хүчинтэй болгон сэргээнэ:

3.1.1.жолоочийн үнэмлэхийн хугацааг сунгасан;

3.1.2.шүүгч, прокурор, эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр;

3.1.3.тээврийн хэрэгсэл жолоодоход эрүүл мэндийн хувьд тэнцэхийг эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтээр тогтоосон;

3.1.4.жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо дууссан, эсхүл Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан зөрчлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан иргэн зохих журмын дагуу жолоодох эрх сэргээх шалгалтад тэнцсэн.

3.2.Энэ журмын 3.1.4-т заасан тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх шалгалтад орох хүсэлт гаргасан иргэн дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

3.2.1.эрүүл мэндийн үзлэгийн хуудас;

3.2.2.жолоодох эрхийн үнэмлэхний үнэ тушаасан баримт;

3.2.3.жолоодох эрхийн лавлагаа.

3.3.Тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх шалгалтыг нийслэлд цагдаагийн төв байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгж, орон нутагт нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага тус тус зохион байгуулна.

### **Дөрөв. Бусад**

4.1.Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан болон эрх сэргээх шалгалт авсан тухай мэдээг сар бүрийн 25-ны дотор цагдаагийн байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгжид хүргүүлнэ.

4.2.Цагдаагийн төв байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгж нь эрх бүхий байгууллагын шийдвэр, эрх бүхий алба хаагчийн буруутай үйлдлээс иргэний жолоодох эрх хасагдсан нь зохих журмын дагуу шалгаж, тогтоогдсон тохиолдолд жолоодох эрх сэргээсэн тухай мэдээллийг санд оруулж, баталгаажуулна.

4.3.Цагдаагийн төв байгууллагын бүртгэл хяналт хариуцсан нэгж нь тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх шалгалтад тэнцсэн хүний материалыг архивын холбогдох журмын дагуу хадгална.

4.4.Энэхүү журмыг зөрчсөн эрх бүхий алба хаагчид холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.